

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	АДГ-2022/18/ШТА-ГА	Шалгагдсан байгууллага:	ЗГХЭГ, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, УОК
Аудитын нэр:	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр дүн үр нөлөө		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын дөрөвдүгээр газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитын менежер Д.Цэрэндорж Ахлах аудитор Д.Цэгмиддорж, Аудитор Б.Буянхишиг, Т.Төмөрбаатар

Хоёр. Аудитын үр дүн:

Аудитын зорилт: Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. ЗГ болон УОК-ын гаргасан шийдвэрийг хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхийн талаар холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрүүд үр нөлөөтэй эсэх;
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд шаардагдах санхүү, хөрөнгө, нөөцийг зохих ёсоор төлөвлөж, бүрдүүлж, үр ашигтай удирдаж байгаа эсэх;
3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад улсын төсөв болон хандив тусламжийг зохих ёсоор бүрдүүлж, зарцуулсан эсэхэд хяналт хийх;

Аудитын хамарсан хүрээ: Аудитад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд оролцсон Засгийн газар, Улсын онцгой комисс, Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, дүүргийн болон өрхийн эрүүл мэндийн төвүүд бусад холбогдох байгууллагуудын 2020, 2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

КОВИД-19-ийн тухай хуулийн 7-10 дугаар зүйлд заагдсан буюу Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно.

Бүлэг 1. Цар тахлын үед УИХ-аас “КОВИД-19-ын тухай хууль”-ийг яаралтай горимоор хэлэлцэн баталж, дагалдах эрх зүйн актуудыг ЗГ, УОК, төрийн байгууллагуудаас боловсруулан гаргасан боловч хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.

ЗГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар анх КОВИД-19-ийн цар тахлын нөхцөл байдлын талаар танилцуулснаас хойш 2020, 2021 онд ЗГ-аас цар тахлаас шалтгаалан хил хаах, хөл хорио тогтоох, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хугацааг сунгах, зэрэглэлийг бууруулах талаар 140 хуралдаан хийж, тогтоол, хурлын тэмдэглэл, МҮЕС-ын захирамж, шуурхай арга хэмжээний шийдвэр УОК-оос 18 тогтоол, МУШС-ын 31 тушаал зэрэг эрх зүйн актыг гаргасан байна.

УОК-оос 2020, 2021 онд 18 тогтоол гарснаас 2021 оны 02, 03 дугаар тогтоолоос бусад тогтоолын хэрэгжилтэд УОКШШ-аас хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

ЗГ-ын 2021 оны 45 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшнийг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр

журам"-ыг баталж, тархалтын 4 түвшин (ногоон, шар, улбар шар, улаан)-тэй байхаар тогтоож, хэрэгжүүлсэн байна.

ДЭМБ-аас 2020 оны 1 дүгээр сард гаргасан “Шинэ коронавирус (КОВИД-19)-ын эхний хариу арга хэмжээний олон нийтийн оролцоо эрсдэлийн үеийн харилцаа холбооны зөвлөмж”-ийн хүрээнд ЭМЯ-аас эрсдэлийн харилцаа холбооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх багийг томилсон бөгөөд тус багийн төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгаагүй байна. Үүнд:

- Мэдээлэл сурталчилгааг хүлээн авах боломжгүй иргэдэд хэрхэн хүргэх;
- Дээд шатны байгууллагын шийдвэрийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргэх мэдээллийн урсгал тогтвортой байх, олон нийтэд хүргэх мэдээлэл тодорхой, ойлгомжтой байх;
- Шинэчлэгдсэн мэдээлэл гарсан даруйд эрсдэлийн харилцаа холбооны ажилтнуудад мэдээллийг түгээх;
- Хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах;

УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7¹ дахь заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, 4 дүгээр сарын 29-ний өдөр “КОВИД-19-ийн тухай хууль”-ийг яаралтай горимоор хэлэлцэн баталж, 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

КОВИД-19-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагууд 15 журам гаргаснаас ХЗДХЯ-д захиргааны хэм хэмжээний актаар 4 бүртгүүлсэн, 11 журмыг бүртгүүлээгүй байна. /Хавсралт-1/

Гамшгийн төрөл бүрээр салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр нарийвчилсан стандарт, үйл ажиллагааны журам зэргийг батлан гаргаж, болзошгүй цар тахлаас урьдчилан сэргийлэхэд бэлэн байх шаардлагатай байна.

УОК-ын даргын 2020 оны 32 дугаар тушаалаар коронавируст халдварын тархалтын үед хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлого, шийдвэрт шинжлэх ухааны үндэслэл, нотолгоотой зөвлөмж боловсруулж, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Эрдэмтдийн зөвлөлийг байгуулж, зөвлөлөөс гаргасан санал, дүгнэлтийг УОК-ын шийдвэрт тусгаж ажиллахыг даалгасан байна.

Эрдэмтдийн зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийг УОК-ын тушаал, төлөвлөгөөнд тусгасан эсэх талаар ажлын тайланг боловсруулаагүй, үнэлгээ хийгээгүй байна.

МУШС, ЭМС-ын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05/A/12 дугаартай хамтарсан тушаалаар “Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах” зааврыг баталсан нь КОВИД-19-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т “цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй тохиолдолд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй авах” гэж заасантай нийцээгүй байна.

УОК-ын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх” тухай 02 дугаар тогтоолоор Монгол Улсын иргэдийг хилээр нэвтэрсэн өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд түр тусгаарлан, шаардлагатай зардлыг тухайн иргэнээс гаргуулахаар шийдвэрлэсэн бөгөөд ДЭМБ-ын судалгаагаар халдварын нууц үе 5.5-19 хоног байх гэж зөвлөсний дагуу 3 дугаар сарын 26-ны өдрөөс тусгаарлалтын хугацааг 21 хоног болгох шийдвэр гаргасан. Мөн 2021 онд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 10, 7 хоног болгон тус тус өөрчлөн тогтоосон байна.

ЭМС-ын 2021 оны A/456 дугаар тушаал, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалт сэргийлэлтийн түр заавар, ХӨСҮТ-ын захирлын A/174 дүгээр тушаал зэргийг үндэслэн гадаадаас зорчин ирсэн хүүхдүүдийг вакцины бүрэн тун хийлгэсэн, өвдөөд эдгэрсэн болон ПГУ-ын шинжилгээ өгсөн эсэхийг харгалзан гэрийн ажиглалтад 14 хоног тусгаарлах болсон байна.

¹ 12.2.7.Дайны байдлын тухай хуулийн 5.1, Дайн бүхий байдлын тухай хуулийн 5.1, Дайчилгааны тухай хуулийн 6.4-т заасан болон онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл;

УОК-ын шийдвэрээр Коронавируст халдвар (КОВИД-19) зөөвөрлөгдөн орж ирэхээс сэргийлэх зорилгоор голомтот бүс нутаг руу зорчих, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах, зогсоох, улсын хилээр нэвтрэх байгаа иргэдэд тархвар зүйн асуумж авах, шинж тэмдгийн тандалт хийх, зорчин ирэгсдийг тусгаарлан ажиглах байр /ТАБ/-д шилжүүлэх зэрэг арга хэмжээ авсан байна.

Хилийн хяналтын чиглэлээр 2020, 2021 онд дараах тогтоол гарсан байна. Үүнд:

- ЗГ-ын 39 дүгээр тогтоолоор БНХАУ-ын болон гуравдагч орны иргэдийн нэвтрэх хөдөлгөөнийг хорьсон;
- ЗГ-ын 172 дугаар тогтоолоор Алтанбулаг боомтын ачаа тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон, Цагааннуур боомтоор хуваарийн дагуу шатахуун тээврийн машиныг нэвтрүүлсэн;
- ЗГ-ын 239 дүгээр тогтоолоор хилийн боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон;
- МУШС-ын 2020 оны 155 дугаар тушаалаар ТАБ-д 14 хоног, гэрийн ажиглалтад 7 хоног байлгах.

БНХАУ-ын Ухань хотоос 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын 31 иргэнийг татан авснаас хойш гадаадын 50 гаруй улсаас 2020, 2021 онуудад эх орондоо буцах хүсэлт гаргасан 45.3 мянган иргэнээс 201 удаагийн тусгай үүргийн нислэгээр 32.1 мянга, ОХУ, БНХАУ-ын хилийн боомтоор 6.6 мянга, нийт 38.7 мянган иргэнийг татан авсан байна.

МУШС-ын 2020 оны 23, 2021 оны 136 дугаар тушаалуудаар “Гадаад улс орнуудаас ирж байгаа иргэдийг коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор түр ТАБ-д байрлах, ор хоногийн төлбөрийг тогтоосон байна.

Хүснэгт 3 ТАБ-ны байрлах ор хоногийн төлбөрийн хэмжээ

Он	Тогтоол	Нас	Төлбөрийн хэлбэр	Нас	Үнэ (мян.төг)	Нас	Үнэ (мян.төг)
2020	23	0-5	Үнэ төлбөргүй	6-17	30.0	18-аас дээш	50.0
2021	136	0-3	Үнэ төлбөргүй	1-12	50.0	13-аас дээш	100.0

Эх сурвалж: МУШС-ын тушаал

УОК-ын шийдвэрээр гадаад улсаас иргэдийг татан авах тусгай үүргийн нислэгийн тийз, ТАБ-д тээвэрлэн хүргэх, тусгаарлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байрны төлбөрт иргэд 32,212.7 сая төгрөгийг ОБЕГ-ын арилжааны банкны дансанд төвлөрүүлснээс МУШС, УОК-ын тушаал шийдвэрийн дагуу үйл ажиллагаанд 592.3 сая төгрөг зарцуулж, төлбөр төлсөн ч гадаад улсаас ирээгүй иргэдийн төлбөр 1,939.6 сая төгрөгийг буцаасан байна. Зарцуулалтыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Гадаад улсаас ирсэн иргэдийн төлбөрийн зарцуулалт(сая төгрөг)

Он	Төлбөр	Зарцуулалт	Үүнээс				
			Байрны төлбөр	МИАТ ТӨХК	Тээврийн зардал	Банкны шимтгэл	Улсын төсөвт төвлөрүүлсэн
2020	23,746.4	23,746.4	19,307.5	4,329.9	108.8	0.2	
2021	5,934.4	5,934.4	5,617.6		197.3	0.5	119.0
Нийт	29,680.8	29,680.8	24,925.1	4,329.9	306.1	0.7	119.0

Эх сурвалж: ОБЕГ-ын санхүүгийн тайлан

Бүлэг 2. Цар тахлын болон гамшгийн үеийн зохион байгуулалт, байгууллагуудын уялдаа холбоо хангагдаагүй, бүртгэл, хяналт сул, вакцинжуулалтын төлөвлөлт, тооцоо судалгааг бүрэн хийгээгүй, зарим арга хэмжээ нь зорьсон үр дүндээ хүрээгүй байна.

Цар тахлын халдвар голомтлон тархах эрсдэлээс сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн УОК, НОК-оос 2021 оны 2 дугаар сард “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлд зохион байгуулсан байна. Үүнд:


- Хөл хорио тогтоож, өрх бүрээс нэг иргэнийг шинжилгээнд хамруулснаар халдварын голомтыг хумих, илрүүлэх, хариу арга хэмжээ авах;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 94.5 хувь, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих иргэдийн хөдөлгөөнийг 96.5 хувь хүртэл хязгаарлан дэглэмийг сахиулах;

Дээрх арга хэмжээг зохион байгуулсан төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт сул, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баримтлаагүй, иргэн, хуулийн этгээдийн оролцоог бүрэн хангаагүй байна.

Цар тахлын үед халдварын голомтод ажиллах эмч, эмнэлгийн ажилчдын хүрэлцээ хангалтгүйгээс шалтгаалж ажлын байрны богино хугацааны сургалтад 2,760 эмнэлгийн мэргэжилтнийг хэсэгчлэн хамруулсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын батлагдсан тохиолдол нийт 724.2 мянга, үүнээс дотоодын халдвар 723.2 мянга, зөөвөрлөгдсөн 1.0 мянган иргэн байна.

Дүрслэл 2. Батлагдсан тохиолдлын тоо (2021.12.31-ний өдрийн байдлаар, мянган хүн)



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар эрэгтэй 900, эмэгтэй 1,101 нийт 2,001 иргэн нас барснаас Улаанбаатарт 1,321, зөөвөрлөгдсөн 2, орон нутагт 678 иргэн байна.

ЭМС-ын 2021 оны А/468 дугаар тушаалаар “Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилж нас барсан тохиолдлын үхлийн шалтгаан, оношийг баталгаажуулах үйл ажиллагааны журам”, “... өвчний онош зөв тогтоогдсон эсэхийг тодорхойлох зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг баталсан байна.

Зөвлөлийн хэлэлцүүлгээр нас барагсдын 1,578 (78.9%) нь архаг суурь өвчтэй байсан ба тухайн өвчний дотор зүрх судасны өвчин хамгийн өндөр буюу 1,179 (74.7%) байна. Мөн (ОУ-ын өвчний ангиллаар) артерийн даралт ихдэлт, чихрийн шижин, уушги болон бөөрний эмгэг, хавдар гэх мэт өвчинтэй хавсарч нас барах тохиолдлууд үүссэн байна.

Эрдэмтдийн багийн тооцооллоор 4 удаагийн хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосноор хүн амыг вакцинуулж дуусах хүртэл хугацаанд халдвар өргөн тархахаас, нас баралт 20-40 мянгад хүрэх эрсдэлийг бууруулсан гэж үзжээ.

КОВИД-19-ийн өвчлөл, хүндрэлийн зэргээс шалтгаалан батлагдсан тохиолдлыг хэвтүүлэн эмчлэхээр аймаг, нийслэлд ЭМС-ын тушаалаар, сумдад аймгийн Засаг даргын шийдвэрээр нийт 27,083 ор дэлгэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

Хэвтэн эмчлүүлсэн 280.9 мянган өвчтөний эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөр 417.2 тэрбум төгрөгийг ЭМДС-аас санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 9. Хэвтэн эмчлүүлсэн иргэдийн судалгаа (2021.03.10-12.31 хүртэл, тэрбум төгрөгөөр)

Харьяалал	Хөнгөн		Хүндэвтэр		Хүнд		Маш хүнд		НИЙТ ДҮН	
	Өвчтөний тоо	Мөнгөн дүн	Өвчтөний тоо	Мөнгөн дүн	Өвчтөний тоо	Мөнгөн дүн	Өвчтөний тоо	Мөнгөн дүн	Өвчтөний тоо	Мөнгөн дүн
Орон нутаг	128,891	122.1	23,360	48.5	3,075	12.8	766	5.4	156,092	188.8
Нийслэл	51,409	49.3	56,237	104.4	14,440	57.6	2,731	17.1	124,817	228.4
Нийт	180,300	171.4	79,597	152.9	17,515	70.4	3,497	22.5	280,909	417.2

Эх сурвалж: ЭМДЕГ цахим бүртгэлийн систем

Эрүүл мэнд болон Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 67/А/268 дугаар хамтарсан тушаалаар “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ”-г баталсан, мөн оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/387/99 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж, төлбөрийн хэмжээг шинэчилсэн байна.

Хүснэгт 8. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, төлбөрийн хэмжээ /мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлбөрийн хэмжээ	
	64/A/268	A/387/99
ПГУ-н шинжилгээний явуулын баг сорьц цуглуулах	5.0	5.0
Анхан шатлалын ЭМБ-аас хөнгөн хэлбэрийн өвчтөнийг гэрээр эмчлэх, зөвлөгөө өгөх	70.0	160.0
Хөнгөн хэлбэрийн өвчтөнийг зориулалтын ор бүхий эмнэлэгт тусгаарлан эмчлэх	650.0	780.0
Эрсдэлтэй хөнгөн, хүндэвтэр өвчтөнийг сумын эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх	850.0	980.0
Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, ЭМТ, хувийн хэвшлийн ЭМБ-д хэвтүүлэн эмчлэх	Хөнгөн	1,050.0
	Хүндэвтэр	-
	Хүнд	2,160.0
	Маш хүнд	4,200.0
Коронавируст халдвар (КОВИД-19)-т өвчний эсрэг дархлаажуулах	5.0	5.0
Тандалтын зорилгоор хийгдэж буй сорьцод шинжилгээ хийх		50.0

Эх сурвалж: Эрүүл мэнд болон Сангийн сайдын хамтарсан тушаал

КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор ДЭМБ-ын зөвлөмж, ЭМС-ын тушаалаар баталсан аргачлалын дагуу 4 нэр төрлийн вакцинд иргэдээ үе шаттайгаар хамруулсан байна.

Хүснэгт 11. Вакцины талаарх дэлгэрэнгүй судалгаа

№	Вакцины нэршил	Үйлдвэрлэсэн улс, үйлдвэр	Суурилсан технологи	Зориулалт
1	Пфайзер “Комирнэти”	АНУ-ын Пфайзер, Герман улсын БиоНТек компани хамтран хөгжүүлсэн	Рибонуклейн хүчлийн (mRNA) шинэ технологи	16-аас дээш насны хүн амд
2	АстраЗененка-Ковишилд “AZD1222/Covishield”	Их Британи улсын Оксфордын их сургууль, Астразенека компани	Аденовирусын вектор	18-аас дээш насны хүн амд
3	Спутник В Гам-Ковид-Вак	ОХУ-ын Н.Ф.Гамалей нэрэмжит үндэсний халдвар судлал микро-биологийн эрдэм шинжилгээний төв	2 төрлийн аденовирусын вектор	18-аас дээш насны хүн амд
4	Вероцелл	БНХАУ-ын Синофарм группийн эмийн компани	SARS-CoV-2 коронавирусын бүлгийн Веро эсийг зөвшөөрсөн	18-аас дээш насны хүн амд

Эх сурвалж: ХӨСҮТ дархлаажуулалтын албаны мэдээ

КОВИД-19-ийн эсрэг вакцинд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор буюу 1-4 тунд 5,357.2 мянган иргэн хамрагдсан байна. Үүнээс зорилтот бүлгийн 12.1 мянган жирэмсэн, 14.2 мянган хөхүүл эмэгтэй, 12-15 насны 338.4 мянган хүүхэд, 16-17 насны 148.5 мянган хүүхэд хамрагдсан байна.

Дүрслэл 4. КОВИД-19-ийн эсрэг вакцинд хамрагдсан иргэдийн тоон мэдээ.



Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,762.4 мянган хүн тун вакцины үлдэгдэлтэй байгаа бөгөөд вакцинжуулалтын явцад зохион байгуулалтаас шалтгаалан 198.2 мянган хүн тун вакциныг устгаж, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Их хэмжээний вакциныг устгахад ХӨСҮТ, дүүргийн ЭМТ-үүд ЭМС-ын 2011 оны А/359 дүгээр тушаалаар баталсан био бэлдмэлийн хаягдлыг устгах журмын 4.1, 4.2, 4.3, 4.4-т дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, дотоод хяналт хангалтгүй байна.

Вакцин хадгалах, хамгаалах, тээвэрлэх үеийн холбогдох анхан шатны баримтын бүрдэл, хөтлөлт хангалтгүй, вакцины зарцуулалт болон цахим /ehealth.gov.mn/ бүртгэлийн тоон мэдээлэл зөрүүтэй /дутуу/ байна.

ЗГ-ын 2021 оны 122 дугаар тогтоолоор цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх зорилгоор вакцины нэг, хоёр дахь тунг хийлгэсэн иргэн бүрд 50.0 мянган төгрөгийн урамшууллыг олгохоор шийдвэрлэж, 2.2 сая иргэнд 111.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгосон байна.

2020-2021 оны хичээлийн жилд ЕБС болон СӨБ-ын хүүхдүүдэд зориулсан 3,139 цагийн теле хичээлийг тогтоосон хуваарийн дагуу нэвтрүүлснээс гадна 104 интерактив хичээл, 2775 цахим хичээл, 50 цахим контент, 30 радио болон аудио хичээл бэлтгэн түгээж, зайн сургалтын бүх агуулга контентуудыг www.econtent.edu.mn (www.medle.mn) цахим хуудаст байршуулж, ЕБС-ын сурагчдад үнэ төлбөргүй ашиглах боломжийг олгосон нь хичээлийн хоцрогдол үүсэхээс сэргийлсэн арга хэмжээ болжээ.

ДЭМБ-аас хийсэн судалгаанд үндэслэн БШУЯ-аас 2021-2022 оны хичээлийн жил эхлэхэд 5 хоног танхим, 9 хоног цахимаар хичээллэх зарчмыг баримталснаар халдвар голомтлон тархах эрсдэлийг бууруулсан байна.

КОВИД-19-ийн тухай хуулиар олгогдсон эрх үүргийн дагуу ХЭҮК-оос холбогдох яам, агентлаг зэрэг 24 байгууллагаас ирүүлсэн тайлан болон тэдгээр байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд үндэслэн 76 арга хэмжээний хэрэгжилтийг харьцуулан судалж 73.7 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлжээ.

УОК-оос КОВИД-19-ийн тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан арга хэмжээний хэрэгжилтийн мэдээ тайланг холбогдох яам, агентлаг болон бусад эрх бүхий байгууллагаас авч нэгтгэсэн боловч хэрэгжилтийг үнэлээгүй байна.

КОВИД-19-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2² дахь заалтыг үндэслэн төрийн жинхэнэ албан тушаалд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,686 байгууллагад 2,539 албан хаагч томилогдсоноос хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг 1,074 албан хаагч хангаагүй нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3-д заасантай нийцээгүй байна

Бүлэг 3. Цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, аж ахуй нэгжийг дэмжих зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлсэн нь үр нөлөөтэй байсан хэдий ч төсвийн орлогыг бууруулах, алдагдлыг нэмэгдүүлэх, гадаад зээлийг өсгөх хүндрэлийг үүсгэсэн байна.

УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор КОВИД-19-ийн цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээнд зориулж 5.1 их наяд (5,091.3 тэрбум) төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.


ЗГ-аас 2021 онд иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, дархлаажуулалтын аяныг идэвхжүүлэх, амьжиргааг дэмжих зорилгоор хүүхдийн мөнгө болон нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэх, эрчим хүч, дулаан, хог хаягдлын төлбөр, ашиглалтын зардлыг төрөөс хариуцах, татвар, НДШ-ээс чөлөөлөх зэрэг арга хэмжээнд 5,429.2 тэрбум төгрөгийг төлөвлөсөн байна.

² Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиас бусад хуулийн дагуу олон нийтийг биечлэн хамруулах арга хэмжээг зохион байгуулах, албан тушаалтныг сонгон шалгаруулахаар хуульчилсан зохицуулалтыг энэ хуулийн үйлчлэл зогссон өдрөөс эхлэн тухайн хуульд заасан хугацааг баримтлан хэрэгжүүлнэ.

ЗГ-аас 2020, 2021 онд ажлын байрыг хадгалах, иргэдийн орлого болон эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийг идэвхижүүлэх /иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор хүүхдийн мөнгө болон нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэх, эрчим хүч, дулаан, хог хаягдлын төлбөр зэрэг ашиглалтын зардлыг төрөөс хариуцах, татвар, НДШ-ээс чөлөөлөх/ зэрэгт нийт 9,567.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Дүрслэл 6. ЗГ-аас 2020, 2021 оны КОВИД-19-ийн эсрэг зарцуулалт.

/тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

ЗГ-аас гаргасан шийдвэрийн дагуу төсөл, арга хэмжээний хүрээнд дараах онцлог гүйлгээнүүд гарсан байна. Тухайлбал

ЗГ-ын 2021 оны 93 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, иргэдийг вакцинжуулах, тэдний орлого, дархлааг дэмжих зорилгоор иргэн бүрд 300,000 төгрөгийн урамшууллыг олгохоор шийдвэрлэж, 3.3 сая иргэнд 997.9 тэрбум төгрөгийг олгосон байна.

ЗГ-ын 2020 оны 167 дугаар тогтоолоор хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний талон зэрэгт 2,981.0 тэрбум төгрөгийн дэмжлэгийг олгосон байна. Үүнд:

- 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100 мянган төгрөгт хүргэн нэмэгдүүлж 2020 онд нийт 1.2 сая хүүхдэд 1,060.4 тэрбум төгрөг, 2021 онд 1,455.2 тэрбум төгрөг, нийт 2,515.6 тэрбум төгрөгийг олгосон байна.
- 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 4 сарын хугацаанд хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн хүүхдэд олгох хүнсний талоны үнийг 16,000 төгрөгт хүргэж 2 дахин нэмэгдүүлж, 118,474 хүүхдэд 19.0 тэрбум төгрөгийн дэмжлэг;
- 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оныг дуустал 8 сарын хугацаанд хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн насанд хүрэгчдэд олгох хүнсний талоны үнийг 32,000 төгрөгт хүргэн 2 дахин нэмэгдүүлж, 123,514 иргэнд 36.4 тэрбум төгрөгийн дэмжлэг;
- Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 70.0 мянган халамж хүртэгчдэд 192.5 тэрбум төгрөг, 72.0 мянган халамж хүртэгчдэд 217.5 тэрбум төгрөгийн дэмжлэг;

ЗГ-ын 2020 оны 211 дүгээр тогтоолоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас айл өрх, ААН-ийн цахилгаан, дулаан, уур, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрийг хариуцахаар шийдвэрлэсэн бөгөөд ЭХЯ-д 868.5 тэрбум, БХБЯ-д 146.5 тэрбум, БОАЖЯ-д 21.8 тэрбум, нийт 1,036.8 тэрбум төгрөгийг олгосон байна.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагаас аливаа төсөл арга хэмжээнд зориулан гаргаж байгаа санхүүжилтийг төсөвтэй уялдуулж тайлагнаж, бүртгэх шаардлагатай байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг эдийн засгийн арга хэмжээний хүрээнд 2020, 2021 онд ААН, иргэдийн ажлын байрыг хамгаалахад 1,489.4 тэрбум төгрөгийн зарим төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна.

Хувийн хэвшлийн ААН-ийн ажиллагсад болон сайн дураар даатгуулагчдын төлөх НДШ-ээс 2020 онд 572.0 мянган даатгуулагчийн 718.1 тэрбум төгрөг, 2021 онд 523.9 мянган даатгуулагчийн 160.4 тэрбум төгрөг, нийт 878.5 тэрбум төгрөгийг хөнгөлж, чөлөөлсөн байна. Тухайлбал:

- 2020 оны 4 дүгээр сарын 01-ээс 6 сарын хугацаанд бүрэн чөлөөлж;
- 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 3 сарын хугацаанд хувь хэмжээг 5 хувь;

- 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 6 сарын хугацаанд хувь хэмжээг 8.5 хувь болгон тус тус хөнгөлсөн байна.

Санхүүгийн салбарт үзүүлэх цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор 2020 оны 3 дугаар сард “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулж, төлбөрийн хүндрэлд орсон 146.3 мянган зээлдэгчийн 1.2 их наяд төгрөгийн хэрэглээний зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулсан байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-417 дугаар “Тусгай зориулалтын компанийн гаргасан 100.0 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг нэрлэсэн үнээр худалдан авах тухай” тушаалын дагуу 2020 онд 34.4 тэрбум төгрөг, 2021 онд 65.6 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг тус тус худалдан авч, баталгаат үнэт цаасыг бүртгэж, цар тахлын эрсдэлтэй нөхцөлд ажилласан 1.2 мянган төрийн албан хаагчийн орон сууцны хэрэгцээг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

ЗГ-ын 42 дугаар тогтоолд иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад 23, эдийн засгаа сэргээхэд 33, нийт 56 арга хэмжээг тусгаж 10 их наяд /10,000.0 тэрбум/ төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 2021 онд 7,354.6 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байна.

Цогц арга хэмжээний хүрээнд улсын төсвөөс 94.0 тэрбум, гадаадын зээл, тусламжаас 136.7 тэрбум, ЭТТ ХК-ийн бондоор 692.5 тэрбум, арилжааны банкны эх үүсвэрээс 4,284.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус бүрдүүлж, нийт 5,207.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

Хүснэгт 17. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа дэмжих арга хэмжээний 2021 оны хэрэгжилт(тэрбум төгрөг)

Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Төлөвлөгөө	Хэрэгжилт /эх үүсвэр/				Нийт гүйцэтгэл
		Улсын төсвөөс	Гадаад зээл, тусламж	Арилжааны Банк	Бонд	
Ажлын байрыг дэмжих зээл	2,000.0	65.8		1,952.6		2,018.4
Ипотекийн зээл	2,000.0			1,012.0		1,012.0
Репо санхүүжилтийн зээл ³	2,000.0			825.5		825.5
ХАА-г дэмжих зээл	500.0	11.4		494.2		505.6
Орон сууцны хорооллын дэд бүтэц	2.3	2.3				2.3
Залуусыг хөдөлмөрт бэлтгэх сургалт	11.8	6.4				6.4
Том төслүүдийн санхүүжилт: Үүнд	840.5	8.1	136.7		692.5	837.3
-Залуус I, Солонго I, II, Ногоон нуур 1008 айлын орон сууцны хороолол төсөл		8.1	8.6			16.7
-УБ хотын төв цэвэрлэх байгууламж барих төсөл			66.5			66.5
-УБ хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл			61.6			61.6
-Томоохон дэд бүтцийн төсөл, уурхайн хөгжүүлэлт					692.5	692.5
Нийт дүн	7,354.6	94.0	136.7	4,284.3	692.5	5,207.5

Эх сурвалж: Сангийн яам

ЗГ-ын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-д тусгасан 56 төсөл, арга хэмжээний явцад үнэлгээ хийж, мэдээлэхийг ЗГХЭГ-т даалгасан боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулж ЗГНС-аас 2020-2021 онд 131.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор ЗГ-ын 27 тогтоол гарч, гүйцэтгэлээр 123.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар хуваарилсан байна.

Дүрслэл 7. ЗГНС-аас 2020-2021 онд олгосон санхүүжилт(тэрбум төгрөг)

³ Арилжааны банк Төв банкны тодорхой хэмжээний үнэт цаасыг худалдан авч түүнийг эргүүлэн авах нөхцөлтэй үнэт цаасны барьцаалсан санхүүгийн хэрэглүүр юм.



Эх үүсвэр: Сангийн яам

ЗГНС-аас 2020-2021 онд ЭМЯ-д олгосон 78.6 тэрбум төгрөгийг зарцуулахдаа нийт 7.8 тэрбум төгрөгийн дараах алдааг гаргасан байна. Тухайлбал:

- Гэрээний иж бүрдэл, биелэлт хангалтгүй 5.3 тэрбум төгрөг.
- Гэрээ дүгнэсэн болон бараа хүлээлцсэн актгүй 2.5 тэрбум төгрөг.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед 2020-2021 онд 58.4 тэрбум төгрөгийн хандив тусламж цугларсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Хүснэгт 18. Хандив тусламж(тэрбум төгрөг)

Д/д	Үзүүлэлт	ЭМЯ-д олгосон					ОБЕГ-т олгосон				
		Мөнгөн хандив		Материалын хандив		Дүн	Мөнгөн хандив		Материалын хандив		Дүн
		тоо	дүн	тоо	дүн		тоо	дүн	тоо	дүн	
1	Хувь хүн, иргэд	46	0.3		0.1	0.4	284	0.8	14	1.7	2.5
2	ААНБ	33	1.5		45.9	47.4	96	1.4	140	1.5	2.9
3	Төрийн байгууллага						138	0.8	4	0.1	0.9
4	Төрийн бус байгууллага	15	0.2			0.2	48	0.7	-	-	0.7
5	Олон улсын байгууллага	4	0.5			0.5	5	0.7	22	2.2	2.9
НИЙТ ДҮН		98	2.5		46.0	48.5	571	4.4	180	5.5	9.9

Олон улсын байгууллага, иргэд, ААН-ээс мөнгөн болон мөнгөн бус хандивыг МУШС, ЭМС, ОБЕГ-ын даргын тушаалаар харьяа болон шаардлагатай байгууллагуудад хуваарилж, зарцуулсан анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, зарцуулалтыг олон нийтэд ил тод тайлагнаагүй нь КОВИД-19-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасантай нийцэхгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитаар **“КОВИД-19-ийн цар тахлын улмаас нийгэм, эдийн засаг, иргэдийн эрүүл мэндэд учирсан сөрөг нөлөөллийг үнэлэх, үр дагаврыг урьдчилан тооцох боломжгүй байна”** гэсэн ерөнхий дүгнэлтийг өгсөн.

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- КОВИД-19-ын тухай хууль болон нийт 160 гаруй эрх зүйн актуудыг УИХ, ЗГ, УОК, төрийн байгууллагуудаас боловсруулан гаргасан байна.
- “КОВИД-19-ын цар тахалтай холбоотой гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтийг ЗГХЭГ, УОК-оос үнэлж, дүгнээгүй байна.
- КОВИД-19 цар тахлыг эмчлэх улаан бүсэд ажиллах эмч, эмнэлгийн ажилтны хүрэлцээ хангалтгүй, ажлын ачаалал ихэссэн зэргээс шалтгаалж иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар буурах эрсдэл үүссэн байна.
- Цар тахлын үед төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт, уялдаа хангагдаагүй, судалгаа, бүртгэл бүрэн хийгдээгүй зэргээс зарим арга хэмжээ зорьсон үр дүндээ бүрэн хүрээгүй байна.
- Иргэдийн ахуй амьдралын нөхцөл байдлаас хамаарч дархлаа суларсан, иргэдийн дунд архаг суурь өвчлөл өргөн тархсан нь коронавируст халдварт өртөх, өвчин хүндрэх, нас барах эрсдэл нэмэгдэх шалтгаан болсон байна.
- Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа цахим бүртгэл, хөтлөлтийн явц удааширсан, шатлалын эмнэлгүүдийн мэдээллийн солилцоо хангалтгүй байна.
- Мэргэжлийн байгууллагын тооцоо, судалгаа, зохион байгуулалт хангалтгүйгээс их хэмжээний вакцины нөөцийг бий болгож чанар байдлыг нь алдагдуулан 198.2 мянган хүн тун вакциныг устгалд оруулж үргүй зардал гаргасан байна.
- Гэрийн тусгаарлалтад эмчлүүлсэн иргэдэд олгосон эмчилгээний эмийн багцын зарцуулалтын бүртгэлийг бүрэн хөтлөөгүй түүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ААНБ-уудад 5,207.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосон нь ХАА, банк санхүү, барилгын салбарын үйл ажиллагааг хэвийн түвшинд явуулахад зохих дэмжлэг болсон байна.
- ЭМЯ нь цар тахлын үед шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалыг худалдан авах, бүртгэж, тайлагнахдаа холбогдох хууль журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.
- Цар тахлын үед олон улсын байгууллага, иргэд, ААН-ээс 58.4 тэрбум төгрөгийн хандив цугласан бөгөөд зарцуулалтын тайлагнал, ил тод байдлыг хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт:

1. Нийгмийг хамарсан халдварт өвчний үед чиг үүргийн байгууллагуудын эрх зүйн байдал, үүрэг чиглэлийн давхардал хийдэл гаргахгүй байхад чиглэсэн хууль эрхзүйн актыг боловсруулж, мөрдөж ажиллах.
2. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх, ажлыг эрчимжүүлэх, зээлдэгчийн зээлийн болон санхүүжүүлэгчдийн төлбөрийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах,
3. Цар тахлын онцгой нөхцөл байдалд үүссэн харилцаатай холбоотой гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтийг үнэлж, Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг баримтлан, Гамшгийн тухай болон бусад хуулиудтай нийцүүлэн сайжруулалт хийж, хэрэгжүүлж ажиллах.

Монгол Улсын Шадар сайдад:

1. Байгууллага иргэдээс өгсөн хандив тусламжийг санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэж тайлагнах, зарцуулалтын ил тод байдлыг хангаж иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэх.
2. Цар тахлын онцгой нөхцөл байдалд үүссэн харилцаатай холбоотой гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтийг үнэлж, Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг баримтлан, Гамшгийн тухай болон бусад хуулиудтай нийцүүлэн сайжруулалт хийж, хэрэгжүүлж ажиллах.

Сангийн сайдад:

1. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх, ажлыг эрчимжүүлэх, зээлдэгчийн зээлийн болон санхүүжүүлэгчдийн төлбөрийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах,

Эрүүл мэндийн сайдад:

1. Нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалах, дархлаажуулах, эрүүл, зөв амьдралын хэв маягт иргэдийн оролцоог хангаж, төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
2. Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг цахимжуулах хөтөлбөрийг эрчимжүүлэх, зохион байгуулалт хяналтыг хэрэгжүүлж ажиллах.
3. (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулах төлөвлөгөө, үйл ажиллагааны зохион байгуулалт, цахим бүртгэл хөтлөлт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.
4. Иргэдийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг нэгдсэн цахим системд бүрэн хамруулах, ЭМДС болон эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, цахим бүртгэлийн нэгдсэн системийг боловсронгуй болгох.
5. Төсвийн болон зээл тусламжийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах.
6. Цар тахлын онцгой нөхцөл байдалд үүссэн харилцаатай холбоотой гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтийг үнэлж, Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг баримтлан, Гамшгийн тухай болон бусад хуулиудтай нийцүүлэн сайжруулалт хийж, хэрэгжүүлж ажиллах.
7. Байгууллага иргэдээс өгсөн хандив тусламжийг санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэж тайлагнах, зарцуулалтын ил тод байдлыг хангаж иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэх.